



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Сургуулийн бүтэц шинэчлэн батлах тухай

Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.2 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.2.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, Төрийн өмчийн зургаан их сургуулийн Дундын удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Засаглалыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 01УЗ/05 дугаар тогтоол, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.7, 3.2 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн үйл ажиллагааг сайжруулах, бүтцийн нэгжүүдийн чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх, санхүүгийн сахилга батыг мөрдүүлэх, санхүүжилтийг үр ашигтай зарцуулах зорилгоор Шинжлэх ухаан технологийн их сургуулийн бүтцийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүтэц шинэчлэн баталсантай холбогдуулан бүтцийн нэгжийн газар, алба, төвийн чиг үүрэг, ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталж мөрдүүлэх, 2022 онд батлагдсан орон тоо, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд багтаан газар, алба, төвүүдийн үйл ажиллагааны дотоод зохион байгуулалтыг оновчтой зохион байгуулж, хууль, эрх зүйд нийцүүлэн ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч /Т.Намнан/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн “Сургуулийн бүтэц батлах тухай” 05 дугаар тогтоолын хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.БАТТОГТОХ



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн
Удирдах зөвлөлийн 2022 оны 11 сарын 11
өдрийн 06 дугаар тогтоолын хавсралт

